



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газрын нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/59/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он	Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Оюунжаргал Утас: 99460422 Цахим хаяг: oyunjargald@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
3. Аудитын тайлан.....	5
3.1 Ерөнхий зүйл.....	5
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	5
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	5
3.4 Материаллаг байдал	6
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	6
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	6
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	7
3.8 Аудитын гол асуудал	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	7
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	7
4. Аудитын илрүүлэлт	7
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	8

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2022-02-22 № 1302/МН
танай -ны № -т

ЗАВХАН АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.РИНЧИНДОРЖ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТУНДРАА

2.1 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Улсын төсөв/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,040,141.21	4,065,246.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,914.82	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,914.82	-
120002	Хүүгийн орлого	5,914.82	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,034,226.39	4,065,246.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	11,034,226.39	4,065,246.40
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	11,034,226.39	4,065,246.40
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,034,226.39	4,070,334.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,034,226.39	4,070,334.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,963,181.18	4,051,811.08
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,788.15	5,088.40
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,788.15	5,088.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,955,393.03	4,046,722.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,955,393.03	4,046,722.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,045.21	18,523.73
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,045.21	18,523.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,045.21	18,523.73

2.2 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Улсын төсөв

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	11,034,216.97	4,065,246.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,914.82	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,914.82	-
120002	Хүүгийн орлого	5,914.82	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,028,302.15	4,065,246.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	11,028,302.15	4,065,246.40
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	11,028,302.15	4,065,246.40
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	11,034,226.39	4,065,246.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,034,226.39	4,065,246.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,963,181.18	4,046,722.68
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,788.15	5,088.40
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,788.15	5,088.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,955,393.03	4,041,634.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,955,393.03	4,041,634.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,045.21	18,523.73
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,045.21	18,523.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,045.21	18,523.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(9.43)	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(9.43)	-

2.3 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Орон нутаг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	145,042.79	89,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,142.79	-
120	Нийтлэг татварын бус орлого	13,142.79	-
120002	Хүүгийн орлого	13,142.79	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	131,900.00	89,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	131,900.00	89,300.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	131,900.00	89,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	145,042.79	89,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,042.79	89,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,148.69	85,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140,148.69	85,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,148.69	85,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,894.11	3,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,894.11	3,800.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,894.11	3,800.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Орон нутаг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	145,042.79	89,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,142.79	-
120	Нийтлэг татварын бус орлого	13,142.79	-
120002	Хүүгийн орлого	13,142.79	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	131,900.00	89,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	131,900.00	89,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	131,900.00	89,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	145,042.79	89,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,042.79	89,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,148.69	85,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140,148.69	85,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,148.69	85,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,894.11	3,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,894.11	3,800.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,894.11	3,800.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газрын нийгмийн халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, ахлах аудитор Д.Оюунжаргал нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газрын нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 217 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлж иргэдийг ажилтай, орлоготой болгох замаар ядуурлыг бууруулж амьжиргааны түвшинг сайжруулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газрын нийгмийн халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 4,154.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 41,545.5 төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 29,081.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/МЯНГАН ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	-	-
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	-	-	-
Нийт хөрөнгө	-	-	-
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	-	-	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	-	-

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 8,458,366.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 8,458,366.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 89,300.0 мянган төгрөгийн, улсын төсвөөс 4,065,246.4 мянган төгрөгийн, нийт 4,135,546.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, сангийн үйл ажиллагаанд 4,132,222.7 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 3,800.0 мянган төгрөгийг, улсын төсөвт 18,523.7 мянган төгрөг, нийт 22,323.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт олгогдоогүй .

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

-

3.8 Аудитын гол асуудал

Байхгүй

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчил илрээгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цахим хуудасад байршуулагдсан 121 мэдээлэх мэдээллээс зайлшгүй байршуулах 6 төрлийн мэдээллийг зөвхөн 12 дугаар сард хугацаа хоцроон мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг 2021.03.24 №60 албан тоотоор ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2022 оноос төрийн үйлчилгээг E-Mongolia цахим сайтаар бүрэн хэрэгжүүлэх боломж бүрдсэн байгаатай холбоотой тус байгууллагад халамжийн ажил гүйлгээний хэрэгжилт

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа илрээгүй.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая

төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.											